

8. Ц. Хандсүрэн. Жужаны аж байдал, соёл, зан заншлын тухай Түүхийн судлал, УБ., 1969, 67—80-р тал
9. Элдэндэй, Ардажав. Монголын нууц товчоон сийрүүлэл тайлбар. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1986. (хуучин бичгээр)
10. Жоужань цзыляо цзилу (Нируны тухай материалын эмхтгэл) Бээжин., 1962.
11. Лидай гэцзу чжуань цзи хуйбянь, Диэрбянь ся цэ (Түүхэн турш дахь угсаатны тухай тусгай тэмдэглэлийн эмхэтгэл), 2-р боть, доод дэвтэр. Шанхай, 1959.
12. Чжунго гудай бафан гэцзу цзяньши (Хятадын эртний умар зүгийн угсаатнуудын товч түүх). Хөх хот., 1979
13. Чжунго гудай ши (шан). Лю Цзэхуа, Ян Чжицзю, Ван Юйчжэ, Ян Исян, Фэн Эркан, Нань Бинвэнь бяньчжэ. Бээжин (Хятадын эртний түүх). 1979
14. Г. Утида, Хожуу Вэй улсын үеийн нируны он дараалсан үйл явдал, -Тоёши —Кэнкю, VIII, № 4, 1943. 51—72, 1—45-р тал.
15. Морьтон үндэстний түүх. 1. Токио, 1971, (японоор)
16. Материалы по истории древних кочевых народов группы дунху. Введение, Перевод и комментарии В. С. Таскина, Москва, 1984,
16. а. Политическая экономия Учебник для высших учебных заведений. Политиздат, Москва, 1988.
17. Arnuff Kollautz, Hisayuki Miyakawa. Geschichte und Kultur eines Völker-Wan derungszeitlichen Nomadenvolkes. Die Joujan der Mongolei und die Awaren in Mit teleuropa. I Teil. Die Geschichte. Bonn, 1970
18. Erich Haenisch, Wörterbuch ru Mandhol un Niuca Tobca'an (Yuan-ch'ao pi-shi) Ge heime Geschichte der Mongolian Wiesbaden, 1962
19. Index to the secret history of the Mongols. Igor de Rachewiltz. Bloomington, 1972
- 20 William J. Baumol, Alan S. Blinder. Economics. Principles and Policy, Fourth edition. Harcourt Brace Jovanovich, Publishers, San Diego, New York, Chicago, Austin, Was hington D. C. , London, Sydney, Tokyo, Toronto, USA, 1988.

**МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦААГ ХЭВИЙН БОЛГОХ
ТАЛААР МАХН, АРДЫН ЗАСГИЙН ГАЗРААС
ХЯТАДЫН ХУВЬСГАЛТ ДЭВШИЛТ ХҮЧИНТЭЙ
ХАМТРАН ТЭМЦСЭН НЬ
(1925—1931 он)**

Р. Отгон

Монголын ардын засгийн газар гадаад байдлаа бэхжүүлэх, юуны өмнө хөрш зэргэлдээ орон Хятадтай харилцаагаа хэвийн болгоход их анхаарал тавьж байв. Гэтэл хятадын харгис хүчин БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байснаас гадна хятадын цэргийн эрхтнүүд БНМАУ-ыг улс төр-эдийн засгийн талаар хяхан хавчихаа улам ихэсгэж түүний хил хязгаар дээр цэргийн үлэмжхэн хүчийг хуралдуулж байжээ. Энэ үед империалист Япон Монгол улсын хувьсгалт байгууллыг устгах, Монголыг эзлэн авч түүнийг ЗХУ-д дайран довтлох дайны талбар болгохыг эрмэлзэж байв. Ийнхүү хятад, Японы цэргийн эрхтнүүд шинэ тулгар Монгол улсын аюулгүй байдал,

тусгаар тогтнолд шууд заналхийлж байв. Гэвч ЗХУ-ын бүх талын тусламж дэмжлэг нь БНМАУ тусгаар тогтносон бүрэн эрхт байдлаа сахин хамгаалахад шийдвэрлэх хүчин зүйл болж байв.

Хэдийгээр Монголын эдийн засаг, соёлын урьдын хоцрогдлоос шалтгаалж улс орны батлан хамгаалах чадварыг бэхжүүлэхэд ихээхэн бэрхшээл тохиолдож байсан боловч МАХН, ардын засгийн газар өөрийн улсын тусгаар тогтнол аюулгүй байдлыг найдвартай хамгаалж чадах ардын армийг байгуулан бэхжүүлэх зорилтыг хэрэгжүүлсэн юм. Тэр тухай ЗХУ-ын Гадаад хэрэг эрхлэх ардын комиссар Г. В. Чичерины 1925 оны нэгдүгээр сарын 24-ний ноот бичигт Монголд байсан цагаантны дээрэмчдийн үлдэгдлийг бүрмөсөн хөөж гаргасан хийгээд тус оронд ардын засаг батжин хөгжсөн учир Зөвлөлтийн цэргийг татан авах нь зүйтэй гэж үзнэ. Монголын засгийн газар энэ шийдвэрийг хүлээн авна гэдэгт найдаж байна гэж дурджээ.¹

БНМАУ-ын ерөнхий сайд Б.Цэрэндорж хариу ноот бичигтээ БНМАУ-ын нутагт байгаа улаан армийн ангиудыг гаргах талаар зөвлөлтийн ноот бичигт өгүүлсэн зүйлтэй санал нэгтэй байгаагаа тэмдэглээд «Манай засгийн газар болбоос Монголын бүх ард түмний өмнөөс манай орныг дээрэмчдийн дарлалаас чөлөөлөгдөх, эрх чөлөөт шинэ цагийн соёл, эдийн засаг эрх тэгш хөгжил ба ардын засгийн замд орох үйлсэд тусалсан улаан армийн мартагдашгүй гавьяаг сэтгэл дүүрэн бахархан тэмдэглээд танаар уламжлан ажилчин тариачны улаан арми, танай улсын засгийн газарт монголын хөдөлмөрч ард түмэн талархан баярлаж, хоёр орны ган бат найрамдалд бат итгэлтэй чин сэтгэлээс талархаж байгааг дамжуулан өгөхийг хүсмой. Хэрвээ монголын хөдөлмөрч ард түмэн түүний засгийн газар гэнэт 1921 оных шиг ямар нэг аюул нөмрөн тохиолдвоос... Улаан арми ба Зөвлөлт Холбоотын хүчинд бат, итгэмой»² гэжээ.

ЗХУ-аас БНМАУ-д сууж байсан элчин сайд Ф. М. Никифоров 1926 онд МАХН-ын V их хурал дээр баяр хүргэж хэлсэн үгэндээ «Хэрэв гадаадын харгисууд хятадын харгисуудыг түлхэж Монголын ард түмний эдүгээгийн олсон эрх ашгийг устгахаар халдан ирвээс манай Холбоот улс зүгээр харж суух үгүй. Эрхгүй аль болох хүчин өгч тусалмой»³ гэжээ. Энэ үг империалист гүрнүүдэд ноцтой сануулга болсон юм.

МАХН, ардын засгийн газрын гадаад бодлогын гол зорилт бол БНМАУ-ын тусгаар тогтнолыг хамгаалах, Азийн улс түмний хувьсгалт хөдөлгөөнийг дэмжих явдал байв.⁴

БНМАУ ЗХУ-тай нягт хамтран ажиллаж, Хятад дахь үндэсний хувьсгалт хөдөлгөөнийг бололцооныхоо хирээр дэмжиж байв.

Хятадын милитарист бүлэглэлүүдийн зүгээс хувьсгалт Монгол улсад цэрэглэн халдах аюул бодитой байсан нөхцөлд хятадын дэвшилт олон нийтийн санаа сэтгэлийг түүний эсрэг хандуулахын үүднээс Хятадын Коммунист нам ба Гоминдан намтай МАХН хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар 1925 онд зарчмын хувьд хэлэлцэн тохирсон нь Монголын ард түмний үндэсний эрх ашиг, Хятадын хувьсгалын зорилгод бүрэн нийцэж байв. Тэрхүү хэлэлцээрийн дотор «Дундад, Монгол улсын Ардын намууд өөрийн гишүүд ба ард түмэндээ Монгол ба Дундад хоёр улсын хувьсгалт ардын ёс журам ба зорилт хийгээд засгийн байдлыг ухуулан танилцуулна... Дундад улсын аль нэгэн этгээд ба бус өөр дайсан этгээдээс Монголд орох буюу хорло-

хыг оролдвоос Дундад улсын Ардын намаас зүй нь ард түмэндээ ухуулж, дарлагдмуй хэмээгч нэгэн адил хэмээн мэдүүлнэ. Хэрэв Дундад улсын Ардын намын этгээдэд ийнхүү явдал тохиолдвоос Монгол Ардын нам мөн ч нэгэн адилын үүргийг хүлээнэ»⁵ гэж дурджээ.

Олон улсын империализм, феодал-компрадор хөрөнгөтний эсрэг өрнөсөн 1925—1927 онуудын хятадын үндэсний хувьсгалын үед МААН Хятадын хувьсгалт хүчтэй нягт холбоо тогтоохыг эрмэлзэж байв.

Шанхайн хятад ажилчид, оюутнуудыг английн харгис цагдаа хэрцгийлэн дарсныг 1925 оны долдугаар сард Монголын Хөдөлмөрчид хилэгнэн эсэргүүцэв. МАХН-ын Төв Хороо амь үрэгдэгсдийн ар гэрт мөнгөн тусламж үзүүлэв. 1927 онд Хятадын ардын хувьсгалт арми Шанхай хотыг чөлөөлөхөд Улаанбаатар хотод нам, эвлэлийн гишүүд, хотын хөдөлмөрчдийн цуглаан болж хятадын ард түмэнд энэхүү чухал ялалтыг тохиолдуулан баяр талархал хүргэсэн байна.

Хятадын хувьсгалт хүчний төлөөлөгчид ч Монголд нэг биш удаа ирж манай ард түмний ололт амжилттай танилцахдаа БНМАУ тусгаар тогтнон оршиж аж ахуй, соёлын байгуулалтдаа их амжилт олсныг зөвшөөрөн энэ тухай бодит мэдээллийг хятадын олон нийтэд хүргэдэг байв. Жишээлбэл 1926 оны дөрөвдүгээр сард Гоминдан болон ХКН-ын зарим удирдах зүтгэлтэн Монголд зочилсон бөгөөд тэр хүү төлөөлөгчдийн тэргүүн Тан Пиншань эх орондоо буцаж очоод сонин хэвлэлд нийтлүүлсэн мэдээндээ улс төр, эдийн засгийн тусгаар тогтнолын замд Монголын ард түмний олсон амжилтыг өндөр үнэлж, «Зөвлөлт Орос улс, Монголыг колоничлож буй» мэтээр Хятадын харгис хэвлэлд гарч байсан гүтгэлэгт цохилт өгсөн байна⁶.

Өгүүлэн буй үеийн турш МАХН хятадын хувьсгалт хүчинтэй ажил хэргийн үр ашигтай хэлхээ холбоо тогтоохыг эрмэлзэн ажиллахдаа бие төлөөлөгч харилцан илгээх, захидал бичиг солилцох, Коминтерний зохих байгууллагын хүрээнд хамтран ажиллах зэрэг зүйл бүрийн хэлбэрийг идэвхитэй ашиглаж байсан юм. 1925—1926 оны туршид МАХН-ын төлөөлөгчид 3-4 удаа Хятадад очиж хоёр намын харилцааг цаашид бэхжүүлэх чиглэл, Хятадын хувьсгалт хүчний байр суурийг бататгахад Монголын талаас үзүүлж болох тусламж дэмжлэг, Хятадын милитаристуудаас Монголын тухайд баримталж буй түрэмгий бодлогыг таслан зогсооход ХКН болон Гоминданы хувьсгалт жигүүрийнхний анхаарлыг хандуулах зэрэг асуудлыг хэлэлцэж байжээ. Тийн хэлэлцэх үед ХКН-ын дотор хэзээнээс оршоор ирсэн хоёр өөр шугамын үзэлтэй ямагт тулгарсаар байсныг тэмдэглэвэл зохино. МАХН Монголын хувьсгалын үйл хэргийг зөв ойлгож түүнийг талархан дэмжсэн нэгэн урсгал байхад тэрхүү бодит байдлыг их гүрний дээрэнгүй үзлийн үүднээс үл тоомсорлон, Монголыг Хятадад хавсарган нэгтгэх бодлого баримталсан хүчин ХКН-ын дотор байсан юм. Гэвч тухайн үеийн турш МАХН улс орныхоо үндэсний эрх ашиг, интернационалч зорилтыг ямагт хослуулж, ХКН-тай холбоо тогтоон ажиллах явдлыг ямагт чухалчилдаг байв. МАХН-ын Төв Хорооны 1925 оны гуравдугаар сарын бүгд хурлын шийдвэрт «Сун взний байгуулсан Гоминдан хэмээх нам ба Хятад улсын Эв Хамт Нам хоёр бол аж үйлдвэрийн ба тариачин ардын ашиг тусыг дэлгэрүүлэхийг үнэхээр хичээж буй тул мөн олон ард учрыг мэдэж буй боловч энэ хир дэлхийн эзэрхэг түрэмгий этгээдийн гараас нэгмөсөн гаргаж чадах хүчнийг хараахан олж чадаагүй боловч хятадын жинхэнэ ард сэрж, түүнээс хөдөлмөрчин

тариачин ардын хөдлөх нь чанга болж, Гоминдан ба Эв хамт намуудын нэр сүр нь олон түмэнд нэвтрэн бататгагдсаар буй тул Хятадын ард түмэн нь эрх чөлөөгөө олох гэсэн замд түргэн түргэнээр алхуулан дэвшиж буй. Ийнхүү Хятадын ард түмэн дэлхийн эзэрхэг түрэмгийчүүд ба тэдэнд биеэ худалдсан хятадын хөрөнгөтнүүдийг эсэргүүцэж, эрх чөлөөгөө эрмэлзэн тэмцэхэд монголын жинхэнэ ард түмэн халуун сэтгэлээр тусламж үзүүлнэ»⁷ гэжээ. Монгол улс Хятадын хувьсгалт хүчинд буу зэвсэг, сум хэрэглэл болон бусад материаллаг зүйлээр тусалж байв. ЗХУ-аас Хятадад явуулж байсан зэр зэвсгийг тээвэрлэж хүргэхэд БНМАУ-ын засгийн газар дэмжлэг үзүүлж байв. Монголын удирдах зүтгэлтнүүд жилийн ба мукдений милитарист бүлгийн эсрэг, хятадын хувьсгалыг дэмжиж байсан генерал Фын Юйсянтай шууд холбоо тогтоон ажиллаж байв.

Хятад дахь чөлөөлөх тэмцэлд идэвхитэй оролцогч Өвөр Монголын хувьсгалт хөдөлгөөний 60 орчим төлөөлөгчид Улаанбаатарт цэргийн ба намын сургуулиудад сурч байжээ⁸. Гэвч хятадын харгис хүчин эрх чөлөөт тусгаар тогтносон Монголд түрэмгийлэх гэсэн бодол санаанаасаа ухрахгүй байлаа. Чан Кайши хувьсгалын эсэргүү эргэлт хийж 1925—1927 оны хятадын хувьсгал дарагдаж, Гоминдан Коммунист намаас холбоогоо тасалсан нь тэдгээрийн БНМАУ-ын эсрэг дайсагнасан явуулгыг идэвхжүүлсэн байна. Хэдий тийм боловч эрх чөлөө, тусгаар тогтнолоо сахин хамгаалахын төлөө Монголын ард түмний хүсэл эрмэлзлэлийг хятадын хөдөлмөрчид ойлгож байгааг моголын ард түмэн сайн ухамсарлаж байв. Москва хотноо Сунь Ятсений нэрэмжит их сургуульд суралцаж байсан хэсэг Хятадын комунистууд 1927 оны эцсээр МАХН-ын Төв Хороонд ирүүлсэн захидалдаа «Бид нар болвоос Дундад улсын эв хамт намын гишүүн бөгөөд манай зорилт дээр үндэс угсаатанд тус тус эрх чөлөө олгохыг зөвшөөрөх тул бид нарт энэхүү асуултын тухай өөр санал байж үл болно... Үүнд эрхэм танай нам, засаг эртнээс нэгэнт Коминтерн ба Холбоот Улстай гар гараа барилцаж, бүх дэлхийн хувьсгалыг тусалцаж буй. Нэн ялангуяа манай Дундад улсын хувьсгалч бөгөөд Лениний суртлыг дагасан бүх дэлхийн хувьсгалч болоход хэрхэн яаж танай үнэн учир байдлыг мэдэхгүй байх ажээ. Нэгэнт энэ учир байдлыг мэдэж агаад хэрхэн яаж гадаад Монголын нам, засгийг итгэхгүй байх ажээ. Эл зүйлийн үнэн байдал нүдэнд үзэгдэж байгаа нь... гагцхүү Холбоот Улс ба Гадаад Монгол нь манай үнэн жинхэнэ сайн нөхөр болно»⁹ гэжээ.

1929 оны нэгдүгээр сарын 14-ний БНМАУ-ын засгийн газрын тунхагт «Монгол, Хятад хоёр хил залгаа улсууд бөгөөд хэрэв хятадын засгийн газар Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч түүнтэй нөхөрсөг харилцаа тогтоохыг хүсэх аваас Монголын засгийн газар санал нэг байна. Харин хятадын зүгээс манай ард түмний байлдан олсон тусгаар тогтнол, эрх чөлөөг хязгаарлахыг оролдох ахул... манай улс тийм байдалтай хэрхэвч эвлэрч чадахгүй» гэжээ.

1928—1930 оны турш Хятадын засгийн газар БНМАУ-ын тусгаар тогтнолд өнгөлзсөн өдөөн хатгалга удаа дараа хийсээр байв. Тэд БНМАУ-ыг Хятадын нэгэн муж хэмээн басамжилан нэрийдэж өдөөн хатгасан бичиг цаас ирүүлж байсан юм. Тухайлбал Бээжингийн засгийн газрын ажилчин тариачны асуудлыг эрхэлсэн товчоо, засаг захиргааны аппаратыг өөрчлөн байгуулах зөвлөл зэрэг газруудаас «Монгол мужийн засгийн газарт», «Монгол мужийн хүрээний сяаны дар-

гад» гэх мэтчилэнгээр хаяглан бичиг баримт ирүүлж байжээ. Үүнтэй холбогдуулан БНМАУ-ын засгийн газар 1929 оны нэгдүгээр сарын 14-нд эрс эсэргүүцэл илэрхийлэн тунхаг бичиг нийтлүүлжээ.

Нанкины засгийн газрын тэргүүн Чан Кайши Зүүн хойт Хятадын төмөр замыг эргүүлэн авсны дараа «улааныхны» талхид байгаа Гадаад Монголыг буцаан авна гэж шууд илээр мэдэгдэж байв.¹⁰

1929 оны хавар хуралдсан МАХН-ын Төв Хорооны бүгд хурал «Хятадын цэргийн эрхтэн ба Гоминдан намын этгээд урьдаас онц илүүгээр шунахайран санаа шулуудаж тус улсын бүрэн эрх чөлөөт байдлыг устган, өөрийн нэгэн муж, сяаны газар болгон дарлан авах бодлого, лоозон гарган явуулж байна»¹¹ гэж тэмдэглээд Хятадын хувьсгалт хүчний санаа сэтгэлийг энэхүү түрэмгий явууллагын эсрэг хандуулахын тулд, ер нь Алс Дорнодахины хувьсгалт хөдөлгөөний эрх ашгийн үүднээс Хятадын Коммунист Намтай аль болохоор хамтран ажиллах арга замыг эрж хайхад бэлхэн байгаагаа илэрхийлжээ. Хятадын милитаристуудаас Монголын эсрэг явуулж буй түрэмгий бодлогын эсрэг тэмцэлд хятадын дэвшилт олон нийтийн дэмжлэгийг хүлээхийн хамт Монголын ард түмэн бодитойгоор нүүрлэн ирсэн тэрхүү аюулыг няцаан зайлуулах гол найдвараа Зөвлөлтийн аугаа их ард түмэнтэй байгуулсан найрамдалд зүй ёсоор тавьж байв. Монгол ардын хувьсгалт цэрэгт хандаж гаргасан нэгэн бичигт «Эрт урьдаас Монголын уудам нутагт эзэрхэн, ард түмнийг дарлаж, өөрийн ашгийг дэлгэрүүлж амташсан Хятадын харгисуудын зэрэг этгээд нар Монголыг дахин эзлэн авч хуучин хэвээр мөлжин дарлахыг одоо хүртэл хичээж байна. Хянаваас, тэдгээр улсууд лугаа ямар ч гэрээ найрамдал тогтоосон боловч тийнхүү Монголыг эзэрхэж захирах саналыг орхих үгүй буй за. Энэ мэтийн эзэрхэг этгээд нар манай Монгол улсын зүүн, баруун, өмнө гурван талд хил нийлэх бөгөөд гагцхүү умар зүгт Зөвлөлийн засагт Холбоот Улс хил залгасан нь бусад эзэрхэг улс лугаа адил бус, харин манай олон түмэн ардын зовлон зүдгүүрийг мэдэх учир Монгол ардыг эзэрхэгийн саварт оруулахгүйг хүснэ. Үүнийг манай улсын харьяат хэн хүн хэзээ ч умартахгүй»¹² гэж тэмдэглэжээ.

Чан-Кайшигээр толгойлуулсан хятадын милитаристууд аман мэдэгдэл, айлган сүрдүүлэх болон нууц төлөвлөгөө боловсруулахаас илэрхий шууд үйл ажиллагаанд шилжиж 1930 оны эхээр БНМАУ-ын хилийн ойр, тухайлбал, Синьцзяны орчмоор хүч хуримтлуулж дайран довтлохоор бэлтгэж байв. Хятадууд Цэнгэл, Цагаан гол, Эрт булаг зэрэг газруудаар хилийг нэг бус удаа зөрчиж казак, торгууд нарын эд хөрөнгө, малыг тонон дээрэмдэж, тэднийг албадан хил давуулж аваачиж байсан ба БНМАУ-ын хилийн заставт халдан дайрч байв.¹³ Улс орны бүрэн эрхт байдалд халдан довтолсон өдөөн хатгалгад Монгол ардын хувьсгалт арми шийдвэртэй цохилт өгч байв.

МАХН, Монголын засгийн газар ЗХУ-тай тогтоосон ах дүүгийн найрамдлаа цаашид бэхжүүлэн өргөжүүлэх, улс орноо батлан хамгаалах хүчээ зузаатгахад ихээхэн анхаарал тавьж байжээ. Бүр 1929 оны тавдугаар сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны бүгд хурал олон улсын байдал түгшүүртэй болж БНМАУ-д түрэмгийлэн довтолох аюул хүчтэй болж байгааг цохон тэмдэглэж улс орны батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх явдал тухайн үеийн гол зорилт болсныг заажээ.

Нийтийн дайсны эсрэг монгол, Зөвлөлтийн ард түмний хийсэн

хамтын тэмцлийн ачаар хоёр оронд ардчилсан ба социалист хувьсгалын ололт бэхжиж, БНМАУ, ЗХУ-ын батлан хамгаалах хүчин чадал өсөв. Энэ бүхэн нь Хятадын эрх баригч бүлгийг өөрсдийн цэрэг дайны түрэмгий явуулгаа түр хугацаагаар зогсооход хүргэж БНМАУ-ын тусгаар тогтнолыг сахин хамгаалах бодит нөхцлийг бүрэлдүүлсэн юм.

Энэ үед МАХН ба ХКН-ын хооронд ажил хэргийн харилцааг өргөжүүлэх зарим алхам хийгдэж байжээ. Тухайлбал, 1929 оны намар ХКН-ын Төв Хорооны төлөөлөгчтэй МАХН-ын Төв Хорооны төлөөлөгчид албан ёсны хэлэлцээ хийжээ. Тийм хэлэлцээ хийх тухай МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1929 оны есдүгээр сарын 9-ний тогтоолд «Эдүгээ үеийн гадаадын байдал түгшүүртэйн дээр ялангуяа япон ба хятадын цэргийн эрхтэн эзэрхэг түрэмгий нараас бидний Монголын эрх чөлөөт байдлыг устгахыг эрмэлзэн бүхий үесд мөн улсын доторхи эв хамт намаас хоёр намын хэлхээ холбоо байгуула хаар (төлөөлөгч) ирүүлсэн нь туйлын чухал хэрэг бөгөөд мөн ч манай хоёр намуудаас урьд хэдийгээс хэлхээ холбоог нэгтгэх нь чухал асуудал байсан боловч... тээглэгдэж завсардаж явсан» гэж тэмдэглээд «Манай ардын хувьсгалт нам ба Хятадын Эв хамт намуудын бие биесийг үл итгэх буюу завсардах зүйл огтхон ч үгүй бөгөөд бүх дэлхийн улаан хувьсгалын халуун журмаар харилцахыг угталцуулан хандуулсны тулд одоо даруй дурдсан ёсоор хоёр намын хэлхээ холбоог туйлын зузаан батаар байгуулж, санал хүчийг нэгтгэн дорно зүгийн ба хоёр улсын ард түмний дайсан болох эзэрхэг түрэмгий ба цэргийн эрхтнүүдийг ховх цохин устгах явдлыг»¹⁴ гүйцэтгэнэ гэж дурдсан байна. Ажил хэргийн холбооны ийм эхлэлтэд тулгуурлан хоёр намын харилцааг пролетарийн интернационализмын зарчмын үндсэн дээр цаашид бэхжүүлэхийн тулд 1930-аад оны эхээр зарим нэг, нааштай ахиц гарсан байна. 1930 оны долдугаар сарын 23-нд хуралдсан МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурлын протоколд тэмдэглэснээс үзэхэд ХКН-ын зарим удирдах зүтгэлтэнтэй бие холбоо тогтоож хоёр намын харилцааг өргөжүүлэх талаар хэлэлцэн тохиролцож байжээ. ХКН-ын доторхи мөнөөхөн интернационалч, үндсэрхэх үзэлтэй шугамын өөр өөр бодлоготой тулгарч байжээ. ХКН-ын доторхи үндсэрхэх үзэлтэнгүүд тусгаар тогтносон БНМАУ-ын талаар Чан Кайшийн эрх баригчдаас тэдний л ялгаваргүй бодлого баримталж, Монголыг Хятадад хавсарган нэгтгэх түрэмгий санаархалдаа тус хоёр оронд өрнөж буй хувьсгалт хөдөлгөөнийг ч ашиглах санаархал өвөрлөн ажиллаж байжээ. Энэ нь 1929—1930 оны үед ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоог үнэн хэрэг дээрээ толгойлон ажиллаж байсан Ли Лисанийн явууллагад тодорхой илэрч байсан байна. ХКН-ын Төв Хороонд оруулсан саналын бичигтээ «Хятадад гарсан бослого амжилт олсны дараа Монгол нь Хятад дахь зөвлөлт засагтай нэгдэх тухай улс төрийн тунхаглалыг дав даруй гаргаж, Монгол бол Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Хятад улсын бүрэлдэхүүнд багтсан нэгэн бүгд найрамдах улс мөн хэмээн хүлээх ёстой»¹⁵ гэж Ли Лисань бичжээ.

Ли Лисаний баримталж байсан тэрхүү алдаатай бодлогыг залруулан ХКН-ын стратеги, тактикийн бодлогыг цаашид марксист-ленинист онолын үүднээс боловсруулахын төлөө Ван Мин, Бо Гу нарын зэрэг интернационалч үзэлтэн нар тэмцэж байжээ. Чухамхүү тийм

чиглэлийн төлөөлөгчидтэй хэлхээ холбоо тогтоон, хоёр намын харилцааг хөгжүүлэхэд МАХН ихээхэн анхаарал тавьж байв.

1930 оны эцсээр хуралдсан МАХН-ын VIII их хурал Хятадын милитаристууд хувьсгалт Монгол улс оршин тогтнож буй бодит баримттай ер эвлэршгүй байгаа бөгөөд түрэмгийлэн эзэрхэхийг цаг ямагт бодолхийлсээр байна гэж тэмдэглээд тэрхүү аюул занал нь «бидний Монгол улсын тусгаар бүрэн эрхтэйгээр тогтнох явдалд туйлын хортой бөгөөд цаг ямагт сэргийлэн сэрэмжилбээс зохих зүйлс мөн бөгөөд гагцхүү хятадын Эв хамтын Намаас удирдан явуулж буй хувьсгалын хөдөлгөөн, Дотоод Монголын ядуу ардын хувьсгал улам баттайгаар хөгжиж чадвал хятадын зүгээс халдан ирэх харгис цэргийн дайсны аюул үгүй болж Монгол Ард Улс сая амгалан тайвнаар оршиж байхыг Монголын олон түмэн ардууд гүйцдээр мэдвээс зохино»¹⁶ гэж тэмдэглэжээ.

ХКН-ын дотор интернационалч үндсэрхэг хоёр чиглэлийн тэмцэл өрнөж байсан нөхцөлд МАХН тууштай интернационалч бодлогодоо тулгуурлан хувьсгалт, интернационалч талынхантай эв саналаа нэгтгэн ажиллаж байсан нь тэдний зүгээс халуун талархал хүлээж байжээ. 1931 оны долдугаар сард ХКН-ын Төв Хорооноос ардын хувьсгалын 10 жилийн ойг тохиолдуулан МАХН-ын Төв Хороонд ирүүлсэн захидалд «Хятадын Эв хамт нам гагцхүү хятадын олон эзэрхэг дарлагч ангиудаас Бүгд Найрамдах Монгол Ард Улсад хортой явууллага хийхийг оролдогч этгээдүүдийг эсэргүүцэн сөнөөх бус, мөн тус намын дотор гарсан баруун этгээд болох Ли Лисань нараас үндэс угсааны асуултын тухайд ялангуяа Монголын асуулт дээр Лениний хэлсэн суртлыг эсэргүүцэн буй. Иймд энэ мэт этгээдүүд лүгээ эрс тэс эсэргүүцэх болой. Ийм учраас гагцхүү Хятадын Эв хамт нам ба Хятадын зөвлөлт засгаас, Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг туйлын чанга хатуугаар хамгаалах бөгөөд мөн Бүгд Найрамдах Монгол Ард Улс хэмээн илэрхийгээр зөвшөөрөх болой. Жич бид нар туйлын үнэнээр илэрхийлэн эрмэлзэх нь Хятадын пролетари нар ба тариачин нар болбоос Монголын хөдөлмөрчин ядуу олон ард лугаа хэлхээ холбоо байгуулахыг туйлын хүснэ. Үүний урьд ах дүүгийн халуун холбоо байсангүй асан. Иймд эдүгээ бид нар гар гараас барилцан хамт явж дайсан лугаа тэмцэж сөнөөхийг хүснэ»¹⁷ гэжээ. МАХН-ын Төв Хорооны урилгаар ХКН-ын төлөөлөгч хэсэг нөхөд Монголын ардын хувьсгалын 10 жилийн ойн баярт оролцжээ.

Хятадын хувьсгалыг тууштай дэмжигч марксист-ленинист намаар удирдуулсан тусгаар тогтносон БНМАУ оршин тогтнож байгаа нь Хятадын хувьсгал, Хятадын үндэсний эрх ашигт зохистой үйлчлэх чухал хүчин зүйл мөн гэдгийг Хятадын жинхэнэ хувьсгалчид сайтар ойлгож байв. Энэ нь 1931 оны арваннэгдүгээр сарын 6-нд хуралдсан чөлөөлөгдсөн районуудын Бүх Хятадын Зөвлөлийн анхдугаар их хурлын баримт бичгүүдэд тодорхой тусгагджээ. Энэ хурлаас гаргасан тогтоолд «Бүх үндэстнүүдийн тусгаар тогтнох эрхийг ямар ч яриангүй хүлээн зөвшөөрнө» гэж заажээ. Энэ нь Монгол, Төвд, Шинжаан зэрэг хүн амын ихэнх нь хятад бус үндэстэн байгаа газарт хөдөлмөрч олон түмэн нь өөрсдөө засан тогтнох эрхтэй бөгөөд тэд хятадын бүрэлдэхүүнээс гарах, эсвэл өөрийн тусгаар тогтносон улсыг тогтоох, эсвэл хятадын автономит муж болж болно гэсэн үг гэж их хурал цохон тэмдэглэжээ. «Зөвлөлийн Бүгд Найрамдах Хятад Улс болбоос

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнолыг үг дуугүй бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрнө»¹⁸ гэж тэр их хурлаас заасан байна. Ингэж МАХН, ардын засгийн газраас хятадын хувьсгалт дэвшилт хүчинтэй хамтран Монгол, Хятадын харилцааг хэвийн болгохын төлөө их хүч чармайлт гарган тэмцсэн нь зохих үр дүнд хүрчээ.

ЗАРЛААГҮЙ ДАЙНЫ ЭХЭН ҮЕ Б. Чантуу

Монгол Зөвлөлтийн ард түмний найрамдлын бат бэхийг дайсан нэг биш туршин үзсэн бөгөөд Халхын голын районд болсон байлдаан Монгол Зөвлөлтийн ахан дүү армийн хамтын ялалтаар түүхэнд алтан үсгээр бичигдэн үлдсэн юм.

Халхын голын байлдааны ялалт нь империалист түрэмгийлэгчдийн эсрэг ах дүү социалист хоёр орны армийн хороо дивизүүд нэгдмэл командын дор хамтран амжилттай байлдаж ялан дийлсэн анхны туршлага байв. 1930-аад оны үед Японы милитаристууд БНМАУ-ыг түрэмгийлэн эзлэхийг санаархаж байсан юм. 1934 оны арван нэгдүгээр сарын 24-нд ЗСБНХУ-ын засгийн газар БНМАУ-ын засгийн газрын хүсэлтээр манай улстай аман хэлэлцээр байгуулсан ёсоор, хэрэв манай хоёр орны аль нэгэн рүү халдан довтолох аюул учирвал харилцан бие биедээ тусламж үзүүлэх тухай үүрэг авсны дотор цэргийн тусламж ч үзүүлэхээр хэлэлцэн тохирсон билээ. Энэ нь цаг үеэ олсон хэлэлцээр байв. 1935-1936 онд Японы түрэмгийлэгчид манай

1. Советско-монгольские отношения. 1921—1974. М., 1975, Т-1, с, 104,
2. Монгол-Зөвлөлтийн харилцаа, 1921—1974. УБ., 1975, боть I, 106 дахь тал.
3. МАХН-ын V их хурал. УБ., 1926, 21 дэх тал,
4. МАХН-ын V их хурал, УБ., 1926, 21 дэх тал.
5. НТА. Ф-1, Д— 32, ХН 5, 109-110 дахь тал
6. «Үнэн», 1926, № 83.
7. МАХН-ын их, бага хурал, Төв Хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэр, 1 дэвтэр, УБ., 1956, 104 дэх тал.
8. М. С. Капица, В. И. Иваненко, Дружба, завоеванная в борьбе, М., 1965, . с, 157,
9. НТА, ф. 1, Д-2, ХН—176, 14 дэх тал.
10. Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх. УБ., 1981, 85—86 дахь тал.
11. Намын VII их хурлаар сонгогдсон Төв Хорооны II бүгд хурлын товч тогтоол, УБ, 1929, 3 дахь тал.
12. БНМАУ-ын Зэвсэгт хүчний архив. Ф-1, Д. 3, ХН—75.
13. Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх. УБ, 1981, 87 дахь тал.
- 14 НТА, Ф-1, Д. 3, ХН-165, 10—11 дэх тал.
15. Коминтерн и Восток. М., 1969, с. 331.
16. МАХН-ын их, бага хурал. Төв Хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэр, хэсэг, УБ., 1956, 278 дахь тал.
17. «Үнэн». 1931 оны долдугаар сарын 2.
18. Советы в Китае, М., 1933, с. 440—441.

Б. Чантуу. «Улаан од» сонины ерөнхий эрхлэгч